Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, төлөвлөлт болон хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж гүйцэтгэв.

Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймгийн Төрийн аудитын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 3/460 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Сайншанд сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, цомхон чадварлаг боловсон хүчинтэйгээр төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангаж ажиллаж, салбар салбартаа үйл ажиллагаагаар тэргүүлэн ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх замаар бизнест шаардлагатай хатуу дэд бүтцийг хөгжүүлж, эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, бизнесийн хөгжлийг дэмжинэ.
- Эдийн засгийн салбаруудын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэн дэмжиж хүн амын эрэлт, хэрэгцээг бүрэн дүүрэн хангана.
- Төр, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хүмүүнлэг, эрүүл, боловсролтой иргэдийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчноо хамгаалж, нөөц баялгийг зүй зохистой ашиглан байгалийн тэнцвэрийг хадгална.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайншанд сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд сумын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгө сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 46,285.4 сая төгрөгийн 1 хувь буюу 462.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 48,840.2 сая төгрөгийн 1 хувь 488.4 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 271.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 356.3 сая төгрөг болж, 84.4 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	271.9	356.3	84.4	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	271.9	356.3	84.4	100

Эх сурвалж Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 151.4 сая төгрөг нь сумын нэмэлт дансны үлдэгдэл, 15.0 мянган төгрөг арилжааны банкны дансанд, 2.1 мянган төгрөг байгаль хамгаалах дансанд, 3.5 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд, 23.1 сая төгрөг сум хөгжүүлэх сангийн дансанд, 161.2 сая төгрөг ахмадын сангийн дансанд байршиж байна.

3.5.3 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 1,269.3, эцсийн үлдэгдэл 1,311.7 сая төгрөг болж, 193.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №..... Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.1	194.0	183.9

Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	16.5	24.5	8.0
Бусад авлага	284.3	58.2	-226.1
Зээлийн авлага	958.5	1,032.8	74.3
Дүн	1,269.3	1,311.7	42.4

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 1,060.4 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн хувь хүнээс авах 2.3 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 24.5 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн хувь хүмүүст олгосон зээл 1,032.8 сая төгрөгийн авлага
- Зүүнбаян Тохижилт байгууллагын цалин илүү олгосон ажилчидтай холбоотой 0.8 сая төгрөгийн авлага байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 27.7 сая, эцсийн үлдэгдэл 11.6 сая төгрөг болж, 16.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №... Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	20,8	4.7	-16.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,9.0	6,9	0
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
Дүн	27.7	11.6	-16.1

Эх сурвалж Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2016, 2019 онд үүссэн 27.7 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- 2016 онд Хамрын хийдийн усан оргилуур барих ажилтай холбоотой 6.9 сая төгрөг бүртгэлтэй.
- 2020 онд Сайншанд сумын 3-р багт шинээр барих сүүдрэвчний зардал 4.7 сая төгрөгийн ажил байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 1,783.8 сая, эцсийн үлдэгдэл 2,073.1 сая төгрөг болж, 289.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	404.1	509.6	105.5
Хангамжийн материал	1,372.5	1,556.1	183.6
Мал амьтад	6.2	7.4	1.2
Дүн	1,738.8	2,073.1	289.3

Эх сурвалж Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч нөөцөлсөн, мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 49,750.5 сая, эцсийн үлдэгдэл 55,951.2 сая төгрөг болж 6,200.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	27,702.1	32,462.6	3,760.6
Тээврийн хэрэгсэл	1,704.3	1,826.5	122.2
Машин тоног төхөөрөмж	2,731.1	3,169.7	438.6
Тавилга, эд хогшил	1,671.5	1,885.8	214.3
Зам гүүрний байгууламж	2,703.7	3,567.2	863.5
Номын фонд	260.6	294	33.4
Бусад үндсэн хөрөнгө	8,871.1	9,543.7	672.7
Программ хангамж	34.7	69.3	34.6
Бусад биет бус хөрөнгө	3,071.5	3,125.9	54.4
Дүн	49,750.5	55,951.2	6,200.8

Эх сурвалж Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 316.4 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 375.0 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 682.3 сая төгрөг, дахин үнэлгээгээр 48.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 293.3 сая төгрөг, акталсан 231.3 сая төгрөг, бусад 269.2 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх ТАХ-д гүйцэтгэгчээр “Энх Ариун хүслэн” ХХК шалгарч урьдчилгаа авсан боловч ажлаа гүйцэтгэлгүй он дамнасан 4.7 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 266.7 сая, эцсийн үлдэгдэл 22.9 сая төгрөг болж, 243.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/ хувь	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	266.6	22.9	-243.8	-1164.1%
Хуримтлагдсан үр дүн Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү				
Дүн	266.6	22.9	-243.8	-1164.1%

Эх сурвалж Сайншанд сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 02/04 дугаар тогтоолд тайлант онд 1,710.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,988.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	180.0	188.8	8.81	104.90
Хөрөнгийн орлого	680.9	633.0	(47.97)	92.96
Хөрөнгө борлуулсны орлого	30.0	85.7	55.72	285.72
Шууд бус орлого	250.2	681.1	430.93	272.25
Бууны албан татвар	5.3	5.9	0.61	111.54
Улсын тэмдэгтийн хураамж	195.0	153.6	(41.36)	78.79
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	85.3	35.0	(50.33)	41.01
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	159.8	159.6	(0.25)	99.84
Хүүгийн орлого	-	-	-	
Торгуулийн орлого	124.0	45.5	(78.52)	36.68
Нийт дүн	1,710.6	1,988.2	277.65	116.23

Орон нутгийн орлого нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөрөө тасарсан байна. Хадгаламжийн хүүгийн орлого 48.0 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөлтийн зөрүү болон ковид-19 өвчний нөхцөл байдалтай холбоотой, хувь хүнээс суутгах орлогын албан татвар 430.9 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй орлого орж ирсэн гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөл боловсруулаагүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн орлогыг 18,367.2 сая төгрөгөөр, зардлыг 18,367.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 18,367.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,990.8 сая төгрөгийг урсгал зардалд, 376.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,430.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 845.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 178.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 11,775.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 4,874.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 419.0 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 198.5, нийт 17,267.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 316.4 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлж, 783.1 сая төгрөгийн санхүүжилтийг улс болон орон нутгийн төсвөөс дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 198.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 135.6 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн дансны эхний үлдэгдлийг орлогод төлөвлөсөн нь шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,321.8 сая төгрөг буюу 94.3 хувьтай /1,045.4 сая төгрөгийн хэмнэлттэй/ байгаа нь, цалин, хөлс болон ажил олгогчоос НДШ-ийн зардал 133.7 сая төгрөг зарцуулаагүй, байр ашиглалттай холбоотой зардал 205.4 сая төгрөг зарцуулагдаагүй, сургууль, цэцэрлэгийн хоолны зардал 520.9 сая төгрөг зарцуулаагүй хэмнэсэн шалтгаалсан байна

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 271.9 сая төгрөгийг улсын төсөв, 37.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 13 төсөл, арга хэмжээнд 376.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 357.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 602.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 295.6 сая төгрөг, нийт 898.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Бараа ажил үйлчилгээний зардалд 742.9 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 4.2 сая төгрөг зарцуулж 151.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 158 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	0	1	0			100
Нийт							

Өмнөх аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсөв, харьяа байгууллагуудын төсөвт хийгдэж байгаа төсвийн нэмэлт өөрчлөлт, төсвийн тодотголыг сумын ИТХ-аар батлуулан түүний дагуу хуваарилах талаар 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг сумын Засаг даргын 2020 оны 1-6/375 дугаар албан бичгээр манай байгууллагад ирүүлсэн байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 29 төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 14 байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт 12, хязгаарлалттай дүгнэлт 2 өгсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 алдаа, зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 60.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 35.2 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 12.8 сая төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.0 сая төгрөгийн 3 алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 20 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төлөвлөөгүй байна.

4.1.2 Эрсдэл: Орлогын боломжит эх үүсвэрийг орхигдуулах, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхгүй байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хариу тайлбар ирүүлээгүй болно.

4.2 Орлогын холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Сумын орлогыг төлөвлөхдөө тооцоо, судалгаанд үндэслээгүй, орлогыг бүрдүүлэх эх үүсвэрийн талаар тоо, мэдээлэл байхгүй, мөн гүйцэтгэлд тааруулан орлогыг тодотгодог байна.

4.2.2 Эрсдэл: Орлогын төлөвлөгөөтэй уялдуулан зардлыг үндэслэлгүйгээр төлөвлөх, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Сумын орлогыг бүрдүүлэг иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг бэлтгэж, орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэж боловсруулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:Хариу тайлбар ирүүлээгүй болно.

4.3 Орлогын холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: ИТХ-аас баталсан төсвийн төлөвлөгөө болон нэгтгэлд тайлангийн төлөвлөгөө зөрүүтэй байна.

4.3.2 Эрсдэл: Батлагдсан төсөв, төлөвлөгөө, тайлан мэдээ зөрөх

4.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөгөөний хуваарийг алдаагүй боловсруулж ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:Хариу тайлбар ирүүлээгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

дга-2021/6/ста-ттз

Сайншанд сумын Засаг дарга

Огноо:

Аудитын нэр:

Аудитын код:

2021 Шалгарсан байгууллагын нэр	Аудитын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал	Овог нэр
		1	2	3	4	5
1	ЗДТГ	Тайлант хугацаанд үүссэн татвараас авах авлагын дүнг хөөн шалгахад 2019 оны эцэст татвараас авах 5187.2 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна.	5.2	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
2	ЗДТГ	16.8 сая төгрөгийн 23 нэр төрлийн хөрөнгийн ашиглагдах жилийн мэдээллийг программд оруулаагүйгээс 4704.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцогдоогүй байна.	4.7	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
3	ЗДТГ	Мөнгөн хөрөнгийн данснаас тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн	0,5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
4	ЗДТГ	Нийт 14 төрлийн үйл ажиллагаатай холбоотой 648.2 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байна. Мөнгөн хөрөнгийн журналд 626.8 мянган төгрөгийн орлого бүртгэж 21.4 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан байна. Үүнд: Орлого зарлагыг давхар бууруулсан 11.5 сая төгрөг, ЗАА-ны нэмэлт санхүүжилтийн дансанд андуурч гүйлгээ хийсэн 9.9 сая төгрөг байна.	9.9	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
5	ЗДТГ	Үндсэн хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай СЗДТГ-ын даргын 2020,06,29-ний өдрийн А/32 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байна. 2020 оны 2 улирал, жилийн эцэст эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Жилийн эцсийн байдлаар нийт 207.4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
6	ЗДТГ	Үндсэн хөрөнгийн журналаас элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө байгаа эсэхийг шүүж үзэхэд 392.5 сая төгрөгийн 215 нэр төрлийн хөрөнгө байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
7	ЗДТГ	Сайншанд сумын ИТХ-ын 2020,06,25-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 9.6 сая төгрөгийн 16 нэр төрлийн машин тонтог төхөөрөмж, 2.1 сая төгрөгийн 11 нэр төрлийн тавилга эд хогшил, 2.1 сая төгрөгийн 7 программ хангамж нийт 13.8 сая төгрөгийн хөрөнгө акталж бүртгэлээс хассан байна. Акталсан хөрөнгийг устгаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг

8	ЗДТГ	2020 оны төсвийн жилд бичиг хэргийн материал, тээвэр шатахуун нийлүүлэх, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн эх бэлтгэх, хэвлүүлэх арга хэмжээнд ХАА зарласан байна. Коронавируст халдварын голомтоос дамжин ирсэн иргэдийг тусгаарлах байр, хоолны зардлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд ХАА зарлаагүй, үнийн санал авч харьцуулаагүй, шалгуур үзүүлэлтээр сонгон шалгаруулаагүй байна. МСҮТ, Аварга хөсөгтөн ХХК, Бадрах өргөө ХХК-д 152.3 сая төгрөгийн байр, хоолны зардлын мөнгө шилжүүлсэн байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
9	ЗДТГ	229.1 мянган төгрөгийн 2 акт, 8109.4 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Харин Аудитаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг цалингийн программын бодолттой тулгаж тайлагнах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Оны эцэст Татварын хэлтэст 19613.4 мянган төгрөгийн ХХОАТ илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
10	СШЗАА	Нийт 2028,0 мянган төгрөгийн 12 гэрээ байгуулснаас 1120,0 мянган төгрөгийн орлого орсон. ИТХ-аас тус байгууллагын 2020 оны төсөвт самбарын түрээсийн орлогыг төлөвлөж батлаагүй байна.	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	А.Энхзаяа, Г.Одончимэг
11	СШЗАА	Үндсэн үйл ажиллагаанаас олох 2028,0 мянган төгрөгийн орлогыг төсөвт тусгаж батлаагүй байна. ЗДТГ-т орох 9900,0 мянган төгрөгийн орлогыг ЗАА-ны нэмэлт санхүүжилтийн дансанд андуурч оруулсныг үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.	9.9	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	А.Энхзаяа, Г.Одончимэг
12	5-р багийн Ажлын алба	Орон нутгийн орлогод төвлөрүүлэх нотариатын орлого дансанд авч зарцуулсан	0,4	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
13	5-р багийн Ажлын алба	7 ажилтны эзлийн амралтын дундаж цалинг тооцохдоо унаа хоолны мөнгө оруулан тооцсон байна.	0,3	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
14	5-р багийн Ажлын алба	Ажлаас чөлөөлөгдөж байгаа хүнд урьдчилгаа цалин илүү олгосон боловч ажилласан хугацааны амралтыг бодоогүй	0,1	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
15	5-р багийн Ажлын алба	Эд хөрөнгийн хагас жилийн тооллого хийгээгүй. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хангалтгүй хийгдсэн	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
16	5-р багийн Ажлын алба	Бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор авсан	3.6	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн
17	5-р багийн Ажлын алба	Орон нутгийн орлогын дансанд андуурч бүртгэсэн	0,9	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Ц.Ганзориг, Б.Батсүрэн

Сайншанд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

18	Цэцэрлэг-2	ҮХ-ийн элэгдлийг давтан тооцоолоход 161.2 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.	0.2	Зөвлөмж	Нягтлан бодогч	Г.Ганжаргал
19	Цэцэрлэг-3	Цалин нэмэгдлүүдтэй холбоотой тушаалыг бүрэн ирүүлээгүйгээс горим сорилыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй.	0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Ж.Сарангуа
20	Цэцэрлэг-3	Тайлан, тодруулга, дэлгэрэнгүй бүртгэлтэй үлдэгдлийг тулган шалгахад зөрүү үүсээгүй болно. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэл ирүүлээгүй тул үлдэгдлийг баталгаажуулж чадаагүй.	0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Ж.Сарангуа
21	Цэцэрлэг-5	Тооллогын бүртгэл ирүүлээгүй тул үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Д. Болортуяа
22	Цэцэрлэг-5	Цалингийн дэлгэрэнгүй ирүүлээгүйн улмаас нэмэгдлүүдийг тушаалын дагуу олгосон эсэхийг шалгах боломжгүй байна.	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Д. Болортуяа
23	Цэцэрлэг-9	Акталсан хөрөнгийг данснаас хасахдаа ХЭ-ийг хасалгүй зардлаар бүртгэсэн	1.4	Залруулсан	Нягтлан бодогч	О.Жаргалмаа
24	Цэцэрлэг-9	3-р улирлын үр дүн, шинээр ажилд орсон ажилтнуудын цалин хөлсний тушаал ирүүлээгүйн улмаас уг хугацаанд хамаарах нэмэгдлүүдийг тулгаагүй. Бусдад нь зөрүү үүсээгүй.	0	Албан шаардлага	Нягтлан бодогч	О.Жаргалмаа
25	Сургууль-4	Тайлант хугацаанд 15,446.4 мянган төгрөгийн авлагатай бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал	Х.Отгонбаяр
26	Цэцэрлэг-7	Эрхлэгчийн баталсан тушаалын дагуу нэмэгдэл олгосон эсэхийг тулган баталгаажуулахад 1020.9 мянган төгрөгийн нэмэгдэл илүү олгосон байна.	1.0	Төлбөрийн акт	Эрхлэгч	М.Батгэрэл
27	Цэцэрлэг-7	Авлага өр төлбөр барагдуулаагүй, хууль шүүхээр шалгагдаж буй авлагыг тулган баталгаажуулах боломжгүй гэж ня-бо тайлбарласан	8.1	Зөвлөмж	Эрхлэгч	М.Батгэрэл
28	Цэцэрлэг-7	Цалингаас суутгасан ХХОАТ-ын тооцооны үлдэгдэл 861,3 мянган төгрөгөөр зөрүүтэй.	0.9	Зөвлөмж	Эрхлэгч	М.Батгэрэл
29	Цэцэрлэг-7	НД-д 381.0 мянган төгрөгийн цалин дутуу тайлагнаснаас НДШ 91.4 мянган төгрөгийн НДШ-ийн өр бүртгэгдээгүй.	0.1	Зөвлөмж	Эрхлэгч	М.Батгэрэл

Сайншанд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

30	Цэцэрлэг-7	Татварын албанд төлсөн 170.0 мянган төгрөгийн хогны татварыг цалингийн зардалд тайлагнасан	0.2	Зөвлөмж	Эрхлэгч	М.Батгэрэл
31	Цэцэрлэг-7	Нэмэгдсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй	0.5	Залруулсан	Эрхлэгч	М.Батгэрэл
32	ИТХ	2019,12,11-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор Сайншанд сумын ИТХ-ын төсвийг 128,7 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2020 оны 12.16-ны өдрийн 02/04 дүгээр тогтоолоор 108,0 сая төгрөгөөр төсөвт өөрчлөлт оруулж тодотгож баталсан байна. Төсвийн гүйцэтгэлээр 11.3 сая төгрөгийн дутуу санхүүжилт авч 96.7 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулснаас 537.8 мянган төгрөгийг жилийн эцэст буцаан төвлөрүүлсэн байна.	0	Зөвлөмж	Дарга	Х.Хоролсүрэн
33	ИТХ	Элэгдлийн зардлаар өртгөө бүрэн нөхсөн 121.4 сая төгрөгийн 27 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна.	0	Зөвлөмж	Дарга	Х.Хоролсүрэн
34	ИТХ	Хурлын төлөөлөгч нарт 2131,2 мянган төгрөгийн "Сайншанд сумын ИТХ" гэсэн бичиг бүхий тэмдэглэлийн дэвтэр, бал, хавтас, флаш олгосон, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас Увс аймгийн ИТХ-ын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлаар явахад 4.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын төсвөөс Сайншанд сумын 4-р багт 6,5 сая төгрөгийн сагсан бөмбөгийн талбай байгуулсан,	12.8	Албан шаардлага	Дарга	Х.Хоролсүрэн
35	Сургууль-1	Тайлант хугацааны эцэст ХХОАТ-ын тооцоог урьдчилан төлж авлага үүсгэсэн байна.	0	Зөвлөмж	Захирал	Х.Ариунтогос
36	Цэцэрлэг-11	Холбогдох шаардлагатай материалуудыг ирүүлээгүйгээс "Гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулах, журналын бичилтээс АШБ руу түүвэрлэн шалгах" горим сорил хэрэгжих боломжгүй байна.	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Э.Сайханчимэг
37	Цэцэрлэг-11	Холбогдох шаардлагатай материалуудыг ирүүлээгүйгээс "ҮХ-ийн элэгдлийн тооцооллыг шалгах" горим сорил хэрэгжих боломжгүй байна.	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Э.Сайханчимэг
38	Цэцэрлэг-11	Холбогдох шаардлагатай материалуудыг ирүүлээгүйгээс "Цалингийн нэмэгдлүүдийг тушаалын дагуу олгосон эсэх" горим сорил хэрэгжих боломжгүй байна.	0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Э.Сайханчимэг
39	Цэцэрлэг-11	Тайлант онд үүссэн авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй	2.2	Зөвлөмж	Нягтлан бодогч	Э.Сайханчимэг
40	Тохижилт-Сайншанд	Тайлант хугацааны эцэст 5,897.5 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна	0	Албан шаардлага	Дарга	Б.Жаргалсайхан
ДҮН			60.7			